

# Living the Lotus 12

*Buddhism in Everyday Life*

2024  
VOL. 231



Гадаад салбарын гишүүд Оэшики Нэг хөлгөний баярт оролцов. 2024 он, Токио хот

**Living the Lotus  
Vol. 231 (2024.12)**

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*



## Учрал нь хүндлэх ба ичих сэтгэлийг хөгжүүлдэг - 2

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Бурхны сургаалыг дамжуулах “учрал”

Японы Хэйан (794-1185) он тооллын үед амьдарч байсан хувраг, яруу найрагч Саигёо багштан “Намрын уудам талын өвсний шүүдэр бүрийг цуглуулах ахуйд бадамлянхуа цэцгийн цөөрөм цэлийнэ.” хэмээх шүлэг тэрлэсэн байдаг. Намрын адаг сараас өвөл болох үес улбартан шарлах өвс навчисыг шүүдэр бүрхэх тэрхүү үзэсгэлэнт байгалийн үзэмжийг дүрсэлсэн шүлэг. Шүүдэр нь угтаа мөдхөн алга болдог түр зуурын зүйлийг илэрхийлдэг боловч Саигёо хувраг түүнийг цуглуулах юм бол цэвэр тунгалаг бадамлянхуа цэцгийн цөөрөм бий болно гэж шүлэглэжээ. Эл шүлэг байгаль дэлхийн гайхамшгийг өгүүлсэн мэт боловч үнэндээ Цагаан Лянхуа судрын Хувилгаан балгасаар зүйрлэхүйг үгүүлэх бүлгийн “Энэ буяныг бүгд бээр хураах болтугай, бүх амьтан лугаа бурхны замд орж гэтлэх болтугай.” хэмээх бадгийг илэрхийлдэг ба шүүдэр нь бурханлаг чанар болно.

Саигёо хувраг амьдарч байсан Хэйан он тооллын үед байгалийн гамшиг, аюулт тахал, дайн дажин, өлсгөлөн гачаал тасрахгүй, ард иргэд зовж зүдэрч байсан юм. Тэрээр тийм нийгмийг хараад халаглан харамсаж, ядуурал, зовлон бэрхшээлийг тэсвэрлэн тэвчиж буй ард иргэдийг бүгдийг нь аврахыг хүсэн залбирч байсан биз ээ. Тэр үеэс 900 жилийн дараах өнөөгийн дэлхий ертөнцийн байдал үндсэндээ тэгж их өөрчлөгдөөгүй мэт санагдана. Тийм ч учраас одоо ч гэсэн, хэн бүхэн бурханлаг чанар нь гэрэлтсэн хүмүүсээр дүүрэн бадамлянхуа цэцгийн цөөрөм лугаа адил дэлхий ертөнцийг бүтээхийг хүсэж байгаа нь лавтай.

Үүний төлөө бидний хийж чадах зүйл гэвэл хүн бүр өөрийн бурханлаг чанарыг олж харсны үндсэн дээр зовж шаналж буй хүмүүсийг ойлгох, тусалж дэмжих, улмаар бүх хүмүүс бусдыг хүндэлж, эв нэгдэл бүхий дэлхийг бүтээлцэхэд гар бие оролцдог байхын төлөө хичээх юм. Өөрөөр хэлбэл бурхны сургаалыг түгээн дэлгэрүүлэх хэмээх “учрал” яг одоо, урьд өмнөхөөс ч илүү хэрэгтэй байгаа юм.



## Бурханлаг чанар гэрэлтэх бадамлянхуа цэцгийн цөөрөм бүтээцгээ

Хүндлэх сэтгэл төрөхөөр аяндаа ичих сэтгэл төрдөг гэж би өмнөх сарын дугаарт хэлсэн. Энэ “хүндлэх ба ичих” сэтгэлийн талаар санаандгүй сурч мэдэрсэн гашуун хийгээд талархмаар нэгэн явдал надад тохиолдож байсныг хуваалцъя.

Их сургуулийн 3-р курсийн зун “кэндо”-ийн дугуйлангийн байр (багшийн гэр) -нд 2 сар байрлан хичээллэх болов. Өөрөө хонохоор шийдсэн байж би сар болоод дасгал сургуулилт, цэвэрлэгээ зэргийг хийхээс ядарч туйлдан гэр лүүгээ зугтан харьсан билээ. Манай багш Накамүра Тоожёо гэж хүн маргааш нь гэрт ирээд “Чи одоо миний хүүхэд л гэсэн үг. За гараад ир.” гэж тэрүүгээр нэг чанга дуудаад, мэдээж хэрэг би буцсан юм. Үнэн сэтгэлээсээ намайг зэмлэсэн багшийгаа би одоо ч гэсэн гүнээ хүндэлж талархаж явдаг хэдий ч тухайн үед сэтгэлийн хөөрлөөр “ядаргаатай юм” гэж эсэргүүцэн уурсаж байснаа бас санаж байна. Хүн өсөж хөгжих ухамсар дутуу бол өөртөө дүгнэлт хийхийн оронд уурлаж бухимдан тийнхүү ичгүүргүй зан гаргадаг байх.

Гэхдээ тэр “ядаргаатай юм” гэх сэтгэл нь “цаашид ийм байж болохгүй” гэж өөрийгөө сайжруулах хөдөлгүүр ч болдог. Бидний доторх бурханлаг чанартай зэрэгцэн орших ичих сэтгэл ийнхүү ажиллаж эхэлдэг ба миний жишээн дээр хэлэх юм бол ичих сэтгэлийн ачаар би харилцаагаа хэвэнд нь оруулья гэж сэтгэлээ өөрчилж чадсан юм.

Энэ нь сүсэг бишрэлт хүмүүний наминчлал нь хүнлэг мөн чанарыг хөгжүүлэх чухал хүчин зүйл болдогтой адил.

Хүн бүхэнд орших хүндлэх хийгээд ичих сэтгэл нь хүмүүсийн учрал тохиол дунд л сэрж сэргэдэг. Манай байгууллагын тэдори (сургаал дамжуулах), мичибики (бурхны зам мөрд хөтлөх) үйл ч гэсэн өөрт болоод бусдад тэрхүү сэтгэлийг зааж суулгах чухал ач холбогдолтой. Корона вирусын халдвар хараахан бүрэн намжаагүй байгаа ч, анхаарал болгоомжтой байхын зэрэгцээ ойр тойронд тань зовж шаналж буй хүн байвал тусалж дэмжин, тэр учралаар дамжуулж бурхны зам мөрийг түгээж, амьдарч буй газар, нийгмээ бурханлаг чанар гэрэлтсэн бадамлянхуа цэцгийн цөөрөм хэмээх амар амгалан газар болгох нь бид бүхний үүрэг. Үүнийг мартажгүй байхын тулд өдөр бүр судраа уншихдаа өмнө өгүүлсэн судрын хэсгийг бясалган бодож, “хүн бүрийн бурханлаг чанар гэрэлтсэн сайн сайхан нийгмийг цогцлоохын төлөө хичээх болно” гэж тангараглаж байх хэрэгтэй.

Түүний эхний алхам бол гэр бүл, ажил алба, амьдардаг газраа хүнтэй мэндэлж, бусдад эелдэг нинжин хандаж сурах юм.

Ингээд эцэст нь нэг асуулт асууя. Энэ жилийг эргээд харахад та “ямар хүн” байсан бэ?

“Косей” сэтгүүл, 12-р сарын дугаараас





# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

## Нийгэмлэгийн тэмдэглэлт баяр ёслолууд

### Үрабон ёслол



7 сарын 13-аас 16-ны өдөр болон 8 сарын 13-аас 16-ны өдрүүдийг Обоны (Үрабон) үе гэдэг.

Эл өдөр өвөг дээдсийнхээ сүнсийг энэ хорвоод урьж, хүндэтгэл үзүүлэн тахил өргөж, цагийг хамт өнгөрөөдөг заншилтай.

Газар газраасаа шалтгаалан хүндэтгэлийн ёс нь өөр байдаг ба өвөг дээдсийнхээ буянаар

өнөөдрийн бид бий болсон учраас талархлаа илэрхийлэх өдөр болгон эрхэмлэн тэмдэглэх учиртай.

Рисшо Косей Кай нийгэмлэг ч мөн адил 7 сарын дундуур Үрабон ёслолыг тэмдэглэн судар ном уншдаг.



#### Бяцхан мэдлэг

Шагжамүни бурхны арван их шавийн нэг Модгальяана өлсгөлөнгийн тамд тарчилж байсан талийгаач ээжийгээ багшийнхаа сургаалын дагуу аврахын тулд 7 сарын 15-ны өдөр лам нарт өргөл өргөн залбирсанаар ээж нь тэнгэрийн оронд дэвшсэн гэдэг. Үрабон ёслол энэ домгоос улбаатай.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.





## Их дагагч Мёокоо багшийг дурсах өдөр



Үүсгэн байгуулагчийн хамтаар Рисшо Косей Кай нийгэмлэгийг үүсгэн байгуулсан Мёокоо багш 1957 оны 9 сарын 10-ны өдөр таалал төгссөн. Элдэг зөөлөн, чанга хатууг хослуулсан энэрэнгүй үйлсээрээ олон гишүүдийг аз жаргалд хөтөлсөн түүнийг одоо ч гишүүд “Нигүүлсэхүйн эх” хэмээн дурсан санагалздаг.

Жил бүрийн 9 сарын 10 бол Мёокоо багшийн сургаал түгээхэд зориулсан “Энэрэл нигүүлслийн нэг насны амьдрал”-ыг, мөн түүний хийсэн бүтээснийг эргэн дурсаж, гишүүн бүр нигүүлсэхүйн сэтгэлийн үйлийг хэрэгжүүлэх тангараг өргөдөг өдөр юм.

### Бяцхан мэдлэг

Нигүүлсэх сэтгэл гэдэг үг нь “хайр энэрэл”, “зовлонгоос аврах” гэсэн утгатай хоёр ханз үсгээс бүрддэг.

Хайр энэрэл гэдэг нь өөрийн амьдралыг бусдад аз жаргал авчрахын төлөө зориулахыг хүсэх сэтгэл, харин зовлонгоос аврах гэдэг нь үйл хэргээрээ бусдын зовлон шаналалыг нимгэлэх хүсэл эрмэлзэл гэсэн утгатай.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



## Оны эцсийн тангараг

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу?

12-р сар гарахтай зэрэг хойд зүгийн хүйтэн салхи үлээн өвлийн улирал хаяанд ирлээ. Токиогийн өглөө оройны чимчигнэсэн хүйтний эрч хэдхэн сарын өмнө тамир тасрам халуун өдрүүд үргэлжилж байгаагүй мэт санагдуулна. Уншигч та бүхэн сайн сууцгааж байна уу?

Тэгэхээр энэ сард Нивано ерөнхийлөгч өнгөрсөн сараас эхэлсэн “хүндлэх сэтгэл ба ичих сэтгэл”-ийн ач холбогдлын талаарх айлдвараа үргэлжлүүлэн айлдсан байна.

Бусдын өөрт байхгүй сайн талыг олж хараад өөрийн дутмаг байдлаасаа ичих сэтгэлийг өөрийгөө сайжруулах боломж болгох чухал. Түүнчлэн хүн бүр бурханлаг мөн чанараа сэрээж, зовж зүдэрч байгаа нэгнийг ойлгож, бие биенээ хүндэтгэдэг бадамлянхуан цөөрөм мэт үзэсгэлэнтэй сайхан ертөнцийг бүтээхийн төлөө бид урьд урьдынхаас илүү хичээх хэрэгтэй гэж сургасан.

Бид угаас Бурхан багштай адил бэлгэ билиг, буян хишгийг хүртсэн хэдий ч өөрсдийгөө бусадтай харьцуулснаар сул дорой мэт санагддаг. Түүнээсээ зугтан ихэмсэг бардам зан гаргаж, өөрт тухгүй бодит байдлаас нүд буруулах хандлагатай байдаг. Магадгүй сэтгэлийн сул дорой байдал биднийг ийм зүйл хийхэд хүргэдэг байх.

Бид Рисшо Косей Кай нийгэмлэгийн гишүүн болсон цагаасаа шударга, уян зөөлөн, даруу төлөв байхыг сурдаг. Оны эцсийн завгүй өдрүүдэд би эдгээр сургаалыг сайтар хэрэгжүүлэн бие сэтгэлээ эрүүл байлгахын төлөө бурхны үйлд шамдахаа дахин тангарагласан.



2024 оны 11 сарын 27-ны өдөр Их ариун ордонд болсон номын багшийн цол гардуулах ёслолын дараа цол авсан гадаад салбарын гишүүдийн хамт (урд эгнээний баруун захад Акагава хэлтсийн дарга)




# Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



## 🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



X

